

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн тайлбар, тодруулга .....	7
10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан .....	12
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан .....	14
4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан .....	15
4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

“БӨРТЭ” ТӨААТҮГ-ЫН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ, ХУРАНДАА  
Б.ЭРХЭМБАЯР ТАНАА

2020.03.13 № 06/866  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “БӨРТЭ” ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “БӨРТЭ” ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлан нь материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “БӨРТЭ” ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал


1. Харилцагчтай 24.8 сая төгрөгийн дансны авлагыг тооцоо нийлж, "Тооцооны үлдэгдлийн баталгаа"-аар баталгаажуулаагүй;
2. Дуусаагүй үйлдвэрлэлээс бэлэн бүтээгдэхүүнд шилжүүлэхэд 59.1 сая төгрөгийн бараа анхан шатны нотлох баримтгүй байгаа зэрэг зөрчлүүд нь Санхүүгийн тайлангийн Эрх ба үүрэг, Оршин байх, Тохиолдсон байх, Хэмжилт, Толилуулга ба тодруулга зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## Үүрэг, хариуцлага

"БӨРТЭ" ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

“Бөртэ” ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг тус газрын ерөнхий захирал, хурандаа Б.Эрхэмбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн анхан шатны баримтын бүрдэлт, шилэн дансны мэдээлэл болон авлага барагдуулахтай холбоотой зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Бөртэ” ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Бөртэ” ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Бөртэ” ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын захиалгаар Мэдээлэл-Аудит ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

“Бөртэ” ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгыг “Мэдээлэл-Аудит” ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 40 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн. Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийн 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 76 дугаар бүхий албан бичгээр дахин ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

“Бөртэ” ТӨААТҮГ-ын эрхэм зорилго нь үйлдвэрлэлийн техник, технологийг сайжруулан шинэчилж, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэн, зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэн, санхүү, эдийн засгийн үр ашигтай ажиллан, цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийн чанар, стандартыг сайжруулахад оршино.

“Бөртэ” ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэл нь Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан Зэвсэгт хүчний болон бусад байгууллагуудын хэрэгцээт дүрэмт хувцас, хэрэглэлийг тэдний эрэлт хэрэгцээнд нийцэхүйц чанар стандартын өндөр түвшинд үйлдвэрлэн нийлүүлж, үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах, Төрийн цэргийн бусад байгууллагуудын хэрэгцээт цэргийн дүрэмт хувцас хэрэглэлийг орчин үеийн дэвшилтэт техник, технологийг ашиглан чанарын өндөр түвшинд үйлдвэрлэх, улмаар үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудын оффис болон ажлын хувцас, сургуулийн сурагчдын дүрэмт хувцас хэрэглэлийг үйлдвэрлэн дотоод, гадаадын зах зээлд хөрвөх чадвартай олон улсын жишигт нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэгдэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно. .

“Бөртэ” ТӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

“Бөртэ” ТӨААТҮГ нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Интерактив Даймонд” програм хангамжийг 2019 оны 04 дүгээр сарын 01-ээс ашиглаж эхэлсэн ба өмнө нь санхүүгийн “Макс” программыг ашиглаж байсан байна.

“Бөртэ” ТӨААТҮГ дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад “Бөртэ” ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Тус байгууллага нь үйлдвэрлэл эрхэлдэг бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг болон зардал нь гүйцэтгэлээрээ хянагдах тул нийт үйл ажиллагааны зардлыг суурь болгосон.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлт 2019 оны 3 дугаар улирлын Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын дүн 30,597.7 сая төгрөгөөс тооцон 30.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлаас 47,8 сая төгрөгөөр тооцсон нь тус байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг шалгахын тулд нийт зарцуулалтыг суурь үзүүлэлт болгосон.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Бөртэ” ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 396.4 сая төгрөгөөр буюу 12.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, биет бус хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан ашиг данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/ сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	79.8	217.4	137.6
Авлага	141.0	175.1	34.1
Бараа материал	1,874.6	2,175.8	301.2
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	89.0	0.3	- 88.7
Үндсэн хөрөнгө	1,060.9	1,051.7	- 9.2
Биет бус хөрөнгө	71.2	92.7	21.4
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>3,316.4</b>	<b>3,712.8</b>	396.4
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>512.6</b>	<b>585.8</b>	<b>73.1</b>
Өмч:-төрийн	581.8	581.8	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	70.1	70.1	-
Эздийн өмчийн бусад хэсэг	667.9	667.9	-
Хуримтлагдсан ашиг	1,484.0	1,807.3	323.3
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>3,316.4</b>	<b>3,712.8</b>	<b>396.4</b>

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2019 оны эцсээр тайлант онд хийгдсэн гэрээний төлбөрүүд төлөгдсөнөөс шалтгаалан өссөн байна.

Дансны авлагыг өмнөх оноос 68.0 сая төгрөгөөр барагдуулж, 93.1 сая төгрөгийн нэмэгдэн, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 9.0 сая төгрөгийг урьдчилж төлсөн нь авлагын дансанд нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны өөрчлөлтийн шалтгаан нь үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг ханган явуулахын тулд 190.0 сая төгрөгийн эрээн даавуу, 66.0 сая төгрөгийн албаны дүрэмт хувцасны даавуу, 40.8 сая төгрөгийн агаарын цэргийн хувцасны даавуу болон 4.4 сая төгрөгийн утас болон бусад туслах материалыг худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн өөрчлөлтийн шалтгаан нь тус үйлдвэрийн газарт Батлан хамгаалахын сайдын 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/397 дугаар тушаалаар 60.0 сая төгрөгийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг худалдан авсан, Батлан хамгаалах яамны хөрөнгө оруулалтаар 23.8 сая төгрөгийн тавилга эд хогшил шилжин ирсэн хөрөнгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд үндсэн хөрөнгөнд 93.0 сая төгрөгийн элэгдэл байгуулсан дүнгээр үндсэн хөрөнгө буурсан байна.

Биет бус хөрөнгийн нэмэгдсэн шалтгаан нь 21.4 сая төгрөгийн Санхүүгийн Интерактив Даймонд программ хангамжийг 2019 оны 4 дүгээр сараас эхлэн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж байгаатай холбоотой байна.

Өр төлбөрийн үлдэгдэлд байгууллагуудаас авсан бараа татан авалттай холбоотой 215.5 сая, Нэмэгдсэн өртгийн албан татварт төлөх 129.1 сая, харилцагч байгууллагуудаас захиалгын дагуу 241.2 сая төгрөгийг урьдчилж авсан зэрэг нийт 585.8 сая төгрөгийн өр төлбөр байгаа нь өөрчлөлтөд нөлөөлсөн байна.

Хуримтлагдсан ашиг дансны 323.3 сая төгрөгийн өөрчлөлт нь “Бөртэ” ТӨААТҮГ нь 2019 онд 248.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан, 2018 онд буруу илэрхийлэгдсэн Дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл 74.9 сая төгрөгийг өмнөх үеийн үр дүнгээс залруулсан тооцоо нөлөөлсөн байна.

## **2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн тайлбар, тодруулга**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу хөрөнгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, удирдлага нь энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, үүргийг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Батлан хамгаалахын сайдын 2019 онд батлагдсан “Бөртэ”ТӨААТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3,860.0 сая төгрөгийн орлоготой, 3,676.3 сая төгрөгийн зардалтай, 183.7 сая төгрөгийн ашигтай байхаар баталсан байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлого 4,881.3 сая, бусад орлого 151.9 сая, нийт 5,033.2 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төлөвлөгөөнөөс 1,173.3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Орлого давж биелсэн нь Батлан хамгаалах системийн байгууллагын гэрээт захиалга нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Нийт үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд 4,778.2 сая төгрөгийг зарцуулж, төлөвлөгөөнөөс 1,101.9 сая төгрөгөөр илүү зарцуулсан ба энэ нь гэрээт захиалга болон орлоготой холбоотой байна.

Тайлант онд 255.0 сая төгрөгийн ашигтай ажиллаж, батлагдсан төлөвлөгөөнөөс 71.3 сая төгрөгөөр илүү ашигтай ажилласан байна.



## 10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж, нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 556.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 326.6 сая төгрөгийн алдааг залруулж, 17.0 сая төгрөгийн акт тогтоож, 129.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 83.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайланд дараах алдааг залруулав. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайлангийн Хөрөнгө оруулалтын Мөнгөн гүйлгээнд "Блю скай лэнд" ХХК-иас худалдан авсан Эсгүүрийн КАД машины 60.0 сая төгрөгийг тусгаагүй нь НББОУС-7 болон Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу Мөнгөн гүйлгээний тайланг бэлтгээгүй, мөнгөн гүйлгээг зөв ангилж тайлагнаагүй, санхүүгийн тайлангийн "толилуулга ба тодруулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мөнгөн гүйлгээний тайланд залруулсан.

- Дансны авлагад бүртгэлтэй байсан 34.9 сая төгрөгийн сөрөг утгатай тооцоог нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн "толилуулга ба тодруулга", "оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

- Өглөгийн дансанд "Коттонтекстайл" ХХК-иас авах 2.3 сая төгрөгийн авлага, харилцагчдын гэрээний дагуу урьдчилж төлсөн 152.3 сая төгрөгийн тооцоог өр төлбөр дансанд бүртгэсэн нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар", санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг", "оршин байх", "толилуулга ба тодруулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

- Орлогын дэлгэрэнгүй тайланд харилцахын хүүгийн орлого 2.2 сая төгрөгийг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан зааврын дагуу ангилж бүртгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогын дэлгэрэнгүй тайланд залруулсан.

- "Дуусаагүй үйлдвэрлэлийн нэгтгэл данс"-д сөрөг утгатай 74.9 сая төгрөг тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "оршин байх", "эрх ба үүрэг", "тохиолдсон байх", "хэмжилт", "толилуулга ба тодруулга", "үнэн зөв байдал" зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмчийн өөрчлөлтийн тайланд залруулсан.

Аудитаар илэрсэн 83.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

“Бөртэ”ТӨААТҮГ-ын дараагийн аудитаар анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна.

### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

“Бөртэ”ТӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 146 мэдээлэл байршуулахаас 82 мэдээллийг бүрэн байршуулсан, 46 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 16 мэдээллийг байршуулаагүй байна.

### **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4,412.9 сая төгрөгийн зөрчилд 2,325.4 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлагыг хүргүүлснийг хэрэгжүүлж, нийт өгсөн 5 зөвлөмжийн хэрэгжилт 90 хувьтай байна.

### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Бөртэ”ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Аудитаар илэрсэн залруулагдаагүй 83.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийн дүн нь бидний тогтоосон 47.8 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс хэтэрч байгаа тул хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.

“Бөртэ”ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Авлага данстай холбоотой асуудал

##### 3.1.1 Илрүүлэлт:

Нийт авлагын үлдэгдлийн 15 хувь буюу 24.8 сая төгрөгийг харилцагчтай тооцоо нийлж, "Тооцооны үлдэгдлийн баталгаа"-аар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

##### 3.1.2 Эрсдэл:

- Санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх” батламж мэдэгдэл хангагдахгүй байх;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх.

##### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллагатай үүссэн авлага, өр төлбөрийн тооцоог нийлж баталгаажуулж байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах.

##### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

## 3.2 Бэлэн бүтээгдэхүүн данстай холбоотой асуудал

### 3.2.1 Илрүүлэлт

Дуусаагүй үйлдвэрлэлээс бэлэн бүтээгдэхүүний орлогод авсан анхан шатны баримтыг ерөнхий журналын дүнтэй хөөн тулгахад 59.1 сая төгрөгийн анхан шатны нотлох баримтгүй болон харилцагчаас авсан бараа материалыг бүртгэж авсан байна.

### 3.2.2 Эрсдэл:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх;
- Санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх” батламж мэдэгдэл хангагдахгүй байх.

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

“Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 13.1-д *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”* гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

## 3.3 Шилэн данстай холбоотой асуудал

### 3.3.1 Илрүүлэлт

Тайлант хугацаанд нийт 146 мэдээлэл байршуулахаас 82 мэдээллийг бүрэн байршуулсан, 46 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 16 мэдээллийг байршуулаагүй байна.

### 3.3.2 Эрсдэл:

- Шилэн дансны тухай хууль зөрчигдөх;
- Санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдэл хангагдахгүй байх

### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

“Шилэн дансны хууль”-ийн 6 дугаар зүйл “Шилэн дансны мэдээлэл” заалтыг хэрэгжүүлж ажиллах

### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 09 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	79,791,256.70	217,360,587.02
1.1.2	Дансны авлага	123,042,230.34	164,838,749.26
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	17,930,276.03	9,027,583.95
1.1.4	Бусад авлага	-	1,217,000.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	1,847,684,615.45	2,175,804,853.40
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	88,994,838.43	283,743.60
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	26,880,000.00	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,184,323,216.95</b>	<b>2,568,532,517.23</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,060,877,534.79	1,051,658,500.36
1.2.2	Биет бус хөрөнгө	71,207,240.00	92,650,071.64
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,132,084,774.79</b>	<b>1,144,308,572.00</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,316,407,991.74</b>	<b>3,712,841,089.23</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	239,123,273.19	215,499,787.64
2.1.1.2	Цалингийн өглөг		-
2.1.1.3	Татварын өр	201,368.34	129,126,812.01
2.1.1.4	НДШ–ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	273,291,527.22	241,134,674.39
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		

2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>512,616,168.75</b>	<b>585,761,274.04</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>512,616,168.75</b>	<b>585,761,274.04</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	581,776,709.35	581,776,709.35
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	70,118,900.00	70,118,900.00
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	667,886,485.16	667,886,485.16
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,484,009,728.48	1,807,297,720.68
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>2,803,791,822.99</b>	<b>3,127,079,815.19</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,316,407,991.74</b>	<b>3,712,841,089.23</b>

## 4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	3,418,676,232.45	4,881,328,446.13
2	Борлуулалтын өртөг	3,837,640,757.19	4,587,110,479.27
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>- 418,964,524.74</b>	<b>294,217,966.86</b>
4	Түрээсийн орлого	-	
5	Хүүгийн орлого	2,266,353.86	2,156,494.56
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	
8	Бусад орлого	20,279,972.29	149,758,567.86
9	Борлуулалт, маркетингийн зардал		937,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	138,195,451.15	103,925,812.98
11	Санхүүгийн зардал	89,762,433.47	
12	Бусад зардал	13,261,674.00	86,225,898.64
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	798,714.00	
17	Бусад ашиг ( алдагдал)		
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>- 636,839,043.21</b>	<b>255,044,317.66</b>
19	Орлогын татварын зардал	201,368.35	6,721,676.91
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>- 637,040,411.56</b>	<b>248,322,640.75</b>
<b>21</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>- 637,040,411.56</b>	<b>248,322,640.75</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>- 637,040,411.56</b>	<b>248,322,640.75</b>
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	581,776,709.35			2,121,050,140.04	2,702,826,849.39
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
3	Залруулсан үлдэгдэл	581,776,709.35			2,121,050,140.04	2,702,826,849.39
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				- 637,040,411.56	- 637,040,411.56
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт			70,118,900.00		70,118,900.00
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		667,886,485.16			667,886,485.16
9	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	581,776,709.35	667,886,485.16	70,118,900.00	1,484,009,728.48	2,803,791,822.99
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				74,965,351.45	74,965,351.45
11	Залруулсан үлдэгдэл	581,776,709.35	667,886,485.16	70,118,900.00	1,558,975,079.93	2,878,757,174.44
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				248,322,640.75	248,322,640.75
13	Бусад дэлгэрэнгүй орлого					-
14	Өмчид гарсан өөрчлөлт					-
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
17	2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	581,776,709.35	667,886,485.16	70,118,900.00	1,807,297,720.68	3,127,079,815.19



#### 4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>4,258,281,815.28</b>	<b>5,671,996,827.20</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,924,618,718.01	5,646,815,490.34
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	34,020,336.00	
1.1.4	Буцаан авсан албан татвар	4,087,635.85	
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	295,555,125.42	25,181,336.86
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>4,537,327,432.16</b>	<b>5,476,583,990.84</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,263,673,240.93	1,326,235,655.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	341,112,450.31	425,525,273.23
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,042,975,189.94	3,432,099,854.06
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	55,374,819.71	-
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	7,957,738.57	7,082,000.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	332,194,353.01	216,587,913.47
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	494,039,639.69	69,053,295.08
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(279,045,616.88)</b>	<b>195,412,836.36</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>2,266,353.86</b>	<b>2,156,494.56</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	2,266,353.86	2,156,494.56
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>-</b>	<b>60,000,000.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		60,000,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>2,266,353.86</b>	<b>- 57,843,505.44</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		

<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>200,000,000.00</b>	
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	200,000,000.00	
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>200,000,000.00</b>	
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	200,000,000.00	
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>		
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>276,779,263.02</b>	<b>137,569,330.32</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>356,570,519.72</b>	<b>79,791,256.70</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>79,791,256.70</b>	<b>217,360,587.02</b>

**5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	<b>“Бөртэ” ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит</b>	Аудитын код:
<b>2020.03.15</b>			САГ-2020/52/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>“Бөртэ” ТӨААТҮГ</b>		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Нийт авлагын үлдэгдлийн 15 хувь буюу 24.8 сая төгрөгийг харилцагчтай тооцоо нийлж, "Тооцооны үлдэгдлийн баталгаа"-аар баталгаажуулаагүй байна.	24.8	Зөвлөмж	Ерөнхий нягтлан бодогч	С.Энхбаатар
2	Дуусаагүй үйлдвэрлэлээс бэлэн бүтээгдэхүүний орлогод авсан анхан шатны баримтыг ерөнхий журналын дүнтэй хөөн тулгахад 59.1 сая төгрөгийн анхан шатны нотлох баримтгүй болон харилцагчаас авсан бараа материалыг бүртгэж авсан байна.	59.1	Зөвлөмж	Ерөнхий нягтлан бодогч	С.Энхбаатар
3	Жилийн эцсийн тооллогоор дутагдсан хөрөнгийг 17.0 сая төгрөгийн барааг Өмч хамгаалах комиссоор шийдвэрлүүлээгүй байна.	17.0	Акт	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Эрхэмбаяр С.Энхбаатар
4	Тайлант хугацаанд нийт 146 мэдээлэл байршуулахаас 82 мэдээллийг бүрэн байршуулсан, 46 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 16 мэдээллийг байршуулаагүй.	-	Зөвлөмж	Ерөнхий нягтлан бодогч	С.Энхбаатар
5	Тайланд онд 129.1 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар хугацаанд нь төлөөгүй өр төлбөрөөр тайлагнасан.	129.1	Албан шаардлага	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Эрхэмбаяр С.Энхбаатар
	<b>Дүн</b>	<b>230.0</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2020 оны 03 дугаар сарын 20

№ 02/65

Улаанбаатар хот

СЭГ- 2020/52/СТА-ТӨЧГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “БӨРТЭ” ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Бөртэ” ТӨААТҮГ-ын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор дутагдсан 17.0 сая төгрөгийн бараа материалыг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.5.2-т “тооллого явуулахын өмнө эд хариуцагчдын хариуцаж байгаа бараа материалын үнэ бүхий зүйл, мөнгөн касс, агуулахыг лацдаж ломбодох болон харуул хамгаалалтын талаар илэрсэн дутагдлыг арилгах арга хэмжээ авахыг холбогдох хүмүүст шаардах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн

ТОГТООХ нь:

1. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор дутагдсан 17.0 сая төгрөгийн бараа материалын үнийг холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлж, байгууллагыг хохиролгүй болгох
2. Тогтоосон актыг барагдуулж, биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “Бөртэ” ТӨААТҮГ-ын Захирал Б.Эрхэмбаяр, Ерөнхий нягтлан бодогч С.Энхбаатар нарт хариуцуулав.

АКТ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
Ц.НАРАНЧИМЭГ  
АХЛАХ АУДИТОР  
Б.ЛХАГВАЦЭНД  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
“МЭДЭЭЛЭЛ АУДИТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ  
Д.ТОВУУДОРЖ

ЗӨВШӨӨРСӨН:

“БӨРТЭ” ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Б.ЭРХЭМБАЯР  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  
С.ЭНХБААТАР

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцаж албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 20

№ 02/146

Улаанбаатар хот

САГ- 2020/52/СТА-ТӨЧГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасан цаглабарт хугацаанд хийсэн “Бөртэ” ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“БӨРТЭ” ТӨААТҮГ нь тайланд онд 129.1 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар хугацаанд нь төлөөгүй өр төлбөрөөр тайлагнасан нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-д “Албан татвар суутган төлөгч нь борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд ногдох албан татварыг доор дурдсан журмаар дараа сарын 10-ны өдрийн дотор төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж, баталсан маягтын дагуу тайлангаа харьяалагдах татварын албанд тушаана” гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нэмэгдсэн өртгийн албан татварыг хуулийн хугацаанд нь төлж, цаашид дээрх алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “Бөртэ” ТӨААТҮГ-ын захирал Б.Эрхэмбаяр, Ерөнхий нягтлан бодогч С.Энхбаатар нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:  
САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
Ц.НАРАНЧИМЭГ  
АХЛАХ АУДИТОР  
Б.ЛХАГВАЦЭНД  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
“МЭДЭЭЛЭЛ-АУДИТ” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Д.ТОВУУДОРЖ

ЗӨВШӨӨРСӨН:  
“БӨРТЭ” ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Б.ЭРХЭМБАЯР  
“БӨРТЭ” ТӨААТҮГ-ЫН ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ  
С.ЭНХБААТАР

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь эхлэх тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.